



# Хичээлийн зорилго

- Гадаад үгийн онцлог, найруулгын үүргийг тодруулах
- Тогтсон нэр томьёо, нэршлийг гадаад үгээр тэмдэглэдэг гэдгийг ойлгох



# Хэл ба нутгийн аялгууны үгийн ялгаа

Үзсэн хичээлээ  
сэргээн саная

## Хэл

- Тухайн улс үндэстний харилцааны гол хэрэглүүр.
- Аман ба бичгийн хэлбэртэй.
- Хэлзүйн нарийн дүрэм тогтолцоотой
- Албан харилцааг зохицуулах гол суурь болдог.
- Суурь аман аялгуу болох халх аялгуунд суурилна.

## Нутгийн аялгуу

- Тодорхой газар оронд оршин буй хэсэг бүлэг хүн харилцана.
- Аман хэлбэр зонхилно.
- Тухайн хэлнийхээ дүрэм журам, зүй тогтолд захирагдана.
- Албан харилцаанд хэрэглэхгүй.
- Үгийн санг баяжуулдаг.
- Уран зохиолын болон сонин нийтлэлийн найруулгад хэрэглэнэ

# Гадаад үгийн тухай



Улс үндэстний олон талын харилцаа холбоо өргөжиж, шинжлэх ухаан хөгжихийн хэрээр хэлэнд шинэ юм, ухагдахууныг нэрлэсэн үг байнга орж ирж байдаг.

Тухайн хэлэнд бусад хэлнээс орж ирсэн үгийг гадаад үг гэнэ. Зайлшгүй тохиолдолд оновчтой авч хэрэглэсэн харь үгс нь хэлний үгийн санг баяжуулдаг. Харь хэлнээс шинээр үүссэн эд зүйлийн нэр, олон улсын чанартай үг хэллэг, нэр томьёо зэргийг зээлдэг.

## Жишээ нь:

- ✓ ном, дэвтэр, судар, эрдэнэ, банз, дүнз, цонх, хуушуур, бууз, отор, оточ, лонх, шатар, бэйс, бэйл
- ✓ Хими, физик, геометр, техник, технологи, музей, систем, бактер, доктор, консул, архив, радио, агент



Харь хэлний үг тухайн хэлэнд шууд ба дам хэлбэрээр нэвтэрдэг. Газарзүйн байрлалаасаа хамааран хил залгаа улс орнуудын үг хэллэгт шууд буюу аман ярианы хэлбэрээр илүү нэвтэрдэг бол, алс хол байршилтай улс орны үг хэллэг, нэр томъёо эсвэл бусад хэлээр дамжин бичгээр орж ирдэг. \ шингэсэн, шингээгүй\

- Манж, Хятад, Самгарди, Төвөд, Араб хэлнээс авч хэрэглэсэн үгсийн ихэнх нь гадаад үг гэж танигдахгүй болсон байна.
- Орос хэлнээс шууд орж ирсэн үг байна.
- Энэтхэг, Европ, Азийн бусад хэлнээс шууд орж ирсэн үг байна.
- Техник технологи, шинжлэх ухааны хөгжилтэй холбоотой орж ирсэн үгс байна.

Гадаад үг  
тухайн  
хэлэнд  
хэрхэн орж  
ирдэг вэ?



# Гадаад үгийн найруулгын үүрэг



- ❑ Гадаад үг нь шинжлэх ухаан, хөгжил дэвшил, нийгэм түүхийн нөхцөл байдал, өөр улс түмэнтэй харилцах харилцааны байдлаас шалтгаалан холбогдож орж ирдэг, ямар нэг ойлголтыг оноон нэрлэх нэр томъёоны үүргээр хэрэглэгддэг тул эрдэм шинжилгээ, сонин нийтлэл, албан бичгийн найруулгад түгээмэл тохиолдоно.
- ❑ Уран зохиолын найруулгад нутгийн, тухайн газар орны ялгамжийг гаргах, тэр тухай төсөөлөл өгөх зорилгоор, зохиолын баатрын хэл ярианы ба мэргэжлийн онцлогийг гаргах зорилгоор хэрэглэгддэг.
- ❑ Ердийн ярианы үгсийн дотор гадаад үгийг албаар хэрэглэдэг.

# Гадаад үгтэй холбоотой зөв бичих дүрэм

01

Нэг үгэнд хэд хэдэн өөр эр эгшиг байвал аль өргөлттэй эгшигт нь зохицуулан залгавар залгана. Хэрэв эр эгшиг дээр өргөлт ноогдоогүй байвал эхний эр эгшигт зохицуулан залгавар залгана. Жишээ нь: автобуснаас, прокуророос

02

Орос хэлний "У" үсгийг монгол хэлний "Ү" эгшигтэй адилтган, эм эгшигт тооцож, залгавар залгана. Жишээ нь: клубээс, группийн

03

Гадаад үгийн эцсийн эгшиг өргөлттэй бол хасаж болохгүй. Жишээ нь кино, пальто

04

"К" үсгээр төгссөн эр үгэнд "ий" эгшиг залгана. Жишээ нь: паркийн, маркийг, математикийн, арифметикийн

05


Хоёр үгээс бүтсэн гадаад үгийн сүүлчийн үгийн эгшигт зохицуулан залгавар залгана. Жишээ нь: амперметрийн, агротехникээр

06

Гадаад үгэнд ямар нэг эр эгшиг байхгүй бол эм үгийн "ий" залгана. Жишээ нь: химийн, менежерийг




# ДүГНЭЛТ



➤ Тухайн хэлэнд бусад хэлнээс орж ирсэн үгийг гадаад үг гэнэ.

➤ Тухайн хэлэнд шууд ба дам байдлаар нэвтэрдэг.



➤ Гадаад үг нь аливаа ойлголтыг оноон нэрлэх нэр томьёоны үүргээр хэрэглэгддэг.

➤ Зарим гадаад үг гадаад үгийн шинжээ алдаад үгийн гарал судлалаар гадаад үг гэдгийг тодорхойлохоос аргагүй болсон нутагшсан үг байдаг.



➤ Бүх төрлийн найруулгад хэрэглэнэ.

➤ Зөв бичих дүрэмтэй.

➤ Хэрэглээний хувьд хязгаарлагдмал



